

# АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



АЛТАЙ ХОТ

2019 ОН

## ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын өсөлтөнд аль салбар нь илүү байр эзлэж ямар бүтээгдэхүүнийг илүү хөгжүүлвэл цаашид аж үйлдвэрийн салбар хөгжих вэ гэдэг үүднээс аж үйлдвэрийн индексийг тооцоолж, барилгын салбар аж үйлдвэрийн өсөлтөнд хэрхэн нөлөөлж байгааг Нөлөөллийн хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар excel програмын Data analysis дээр үнэлгээгээр 2000-2018 оны тоо мэдээллийг ашиглан судалсан.

Судалгааны гол үр дүн дараах байдалтай гарсан. Үүнд: (1) Үүнээс харахад тестийн ажиглалтын утга нь 3.88 гарсан байна. Мөн магадлал нь 0.05-аас бага байна. (2) Түүнчлэн t-statistic нь модулиар ойролцоогоор 2-оос их.

Prob буюу магадлал нь 0.05-аас бага байвал ач холбогдолтой гэж үздэг ба манай судалгаан дээр бүх хувьсагчид ач холбогдолтой байна. Ийм учраас барилга гүйцэтгэлийн ажилаас шууд хамааралтайгаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт шаалтгаална гэж үзлээ.

## **АГУУЛГА**

### **I. УДИРТГАЛ**

### **II. ОНОЛЫН ХЭСЭГ**

### **III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

**3.1** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил

**3.2** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт борлуулалт салбараар

**3.3** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт борлуулалт сумдаар

**3.4** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

**3.5** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт ДНБ-д өсөлтөд үзүүлж буй нөлөөлөл

**3.6** Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбар ба барилгын салбарын хамаарлын эконометрикс загварын үнэлгээ

### **IV. ДҮГНЭЛТ/ЗӨВЛӨМЖ**

#### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

#### **ХАВСРАЛТ**

### **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

ХАА - Хөдөө аж ахуй

ААНБ – Аж ахуйн нэгж байгууллага

АҮ – Аж үйлдвэр

## I. УДИРТГАЛ

Улс орны хөгжил, өнөөгийн эдийн засгийн байдлыг дэмжих гол үзүүлэлтүүдийн нэг бол аж үйлдвэрийн салбарын хөгжил билээ. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар нэлээд арга хэмжээ авдаг болсон өнөө үед аж үйлдвэрийн салбарын хөгжил арай хурдацтай явагдах болж байгаа нь ажиглагдаж байна.

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтүүдээр нэгдсэн танилцуулга бэлдэж тэдгээр үзүүлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлж орон нутгийн удирдлагыг дэлгэрэнгүй мэдээллээр хангахад чиглэнэ. Үүнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

- Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл ба борлуулалт 2007-2018 оны үзүүлэлтүүдийг судлах
- Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл ба борлуулалтыг салбараар нь 2007-2018 оны үзүүлэлтүүдийг судлах
- Гол нэрийн бүтээгдэхүүнийг судлах 2007-2018 он
- Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл ба борлуулалтыг сумдаар нь 2007-2018 оны үзүүлэлтүүдийг судлах
- Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жинг тооцох
- Аж үйлдвэрийн салбарын хөгжил нь нийгмийн олон үзүүлэлттэй уялдаа холбоотой байдаг ба тэр дундаас барилгын салбарын хөгжилтэй илүү уялдаа холбоотой байдаг боловуу ийм учраас барилгын салбарын өсөлт бууралт энэ салбарт хэрхэн нөлөөлж байгааг судлах

**Судалгааны объект:** 2018 оны эцсийн байдлаар Мандал-Хүдэр, Алтай-Улиастай Эрчим хүчний үйлдвэр, Тулга-Алтай, Ентүм, Ундарга-Эх, Ундрaм-Оюу, Баярт-Олон, Залуур-Алтай, Залуур-Өргөө, Оюу-Бейкери, Хүслийн наран, Энхлэн-Бейкери зэрэг 54 ААНБ үйлдвэрлэл эрхэлж байна. Энэ жил талх, нарийн боов, хэвийн боов, торт, дарс, хиам, бүх төрлийн гутал, дээл, тоосго, блок, дулаан, цахилгаан, түгээсэн ус, сувагжуулалт, нүүрс, ундаа, жүүс гэх мэтчлэн 25-н нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

**Судалгааны арга:** Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд хийсэн индексийн шинжилгээ нийт үйлдвэрлэлтэд нөлөөллийн хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар excel программ дээр үнэлгээ, шулуун шугамын тэгшитгэл ашигласан болно.

## II. ОНОЛЫН ХЭСЭГ

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийн тайланг санхүүгийн тайлан тэнцэл хөтөлдөг өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, газрууд сарын тайланг дараах үзүүлэлтээр гаргана. Үүнд :

- Нийт бүтээгдэхүүн
- Бүтээгдэхүүний нийт борлуулалт, аж үйлдвэрийн борлуулалт
- Аж үйлдвэрийн ажиллагсад, ажилчид
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гол нэр төрлөөр
- Мэдээнд хамрагдсан байгууллагын тоо

Энэхүү аргачлалд орсон нэр томъёог дараах байдлаар ойлгож, хэрэглэнэ.

Үүнд:

**Бүтээгдэхүүн:** Бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэд завсрын хэрэглээний орц хэлбэрээр, эсвэл хүн амын эцсийн хэрэглээ болж ашиглагдах зорилгоор үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон биет зүйлийг;

**Нийт үйлдвэрлэлт:** Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөр нэгж байгууллагын хэрэглээнд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хэмжээг;

Үйлдвэрийн газрын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тодорхойлно. Үйлдвэрлэлийн арга гэж тайлангийн хугацаанд үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүний өртгөөс дотооддоо үйлдвэрийн хэрэгцээнд хэрэглэсэн өөрийн бүтээгдэхүүний өртгийг хасч нийт бүтээгдэхүүнийг гаргахыг хэлнэ.

Нийт бүтээгдэхүүнд дараах зүйлүүдийг оруулна. Үүнд :

- Үндсэн үйлдвэрлэлийн бүх цех, тасагт үйлдвэрлэгдсэн бэлэн бүтээгдэхүүний өртөг
- Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн бус чанартай ажилд зориулан үйлдвэрлэсэн буюу гадагш борлуулсан хагас боловсруулсан бүтээгдэхүүний өртөг
- Туслах чанарын үйлдвэрлэл, тасгуудын бүтээгдэхүүний өртөг (гадагш борлогдсон тохиолдолд)
- Өөрийн харьяа аж үйлдвэрийн биш аж ахуйн байгууллага буюу бусдын захиалгаар гүйцэтгэсэн аж үйлдвэрийн чанартай ажлын өртөг
- Үйлдвэрлэлийн процесс нь урт хугацаанд явагддаг үйлдвэрт бол дуусаагүй үйлдвэрлэлтийн өртгийн үлдэгдлийн зөрүүг оруулна.

**Бүтээгдэхүүний нийт борлуулалт:** Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээг бүтээгдэхүүний борлуулалт гэнэ. Хэрэв үйлдвэрийн газар бүтээгдэхүүнээ хүн амд борлуулсан бол бүтээгдэхүүний борлуулалтад худалдааны татварыг хассан хэмжээгээр оруулна. Нийт борлуулалтанд тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалт орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнээ үнийг урьдчилан бүрэн төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулалтанд оруулж тооцно.

**Аж үйлдвэрийн борлуулалт:** Энд зөвхөн тухайн үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг оруулж тооцно. Өөрөөр хэлбэл бусад борлуулалт тухайлбал үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний болон үндсэн хөрөнгө, түүхий эд, материал гэх мэт зүйлийг худалдан борлуулсан хэмжээг оруулахгүй. Аж үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт нь гадаад болон дотоод зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний өртгийн нийлбэртэй тэнцүү байна.

**Индекс:** Тухайн үзэгдлийн тодорхой хугацааны өөрчлөлтийг харуулсан харьцангуй хэмжигдэхүүн.

**Үйлдвэрлэлийн индекс:** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан, зөвхөн биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх үзүүлэлт.

**Үйлдвэрлэгчийн үнийн индекс:** Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн (үйлдвэрлэгчийн үнээрх) өөрчлөлтийг илэрхийлэх үзүүлэлт.

**Үйлдвэрлэгчийн үнэ:** Аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ явуулахад гарсан зардал, ашгийг багтаасан үйлдвэрийн газрын үнийг; аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээнд бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ гэсэн хоёр хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөллийг арилгаж, зөвхөн үйлдвэрлэлийн өсөлтийг тодорхойлох зорилгоор статистикийн практикт үйлдвэрлэлийн индексийг ашигладаг. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс нь тухайн хугацаанд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний биет хэмжээний өөрчлөлтийг харуулдаг.

**Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индекс:** Эдийн засгийн үйл ажиллагаан дахь богино хугацааны өөрчлөлт, эдийн засгийн хөгжлийг харуулах нэг шалгуур үзүүлэлт болдог. Түүнчлэн жил, улирлын ДНБ-ий тооцоонд уг индексийг ашиглана.

- Сонгогдсон бүтээгдэхүүний тоо хэмжээ, тэдгээрийн хувийн индекс, бүтээгдэхүүн, бүлэг, дэд салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээнд эзлэх хувийн жин болон тодорхой салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индексийг үндэслэн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг тооцно.

- Энэхүү аргачлалыг аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг тооцоход мөрдлөг болгоно. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийн тооцоонд ашиглагдах үйлдвэрлэгчийн үнийн индексийг “Үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу тооцно.

**Индексийн тооцоонд ашиглах жинг тооцох.** Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг тооцоход дараах 3 түвшний жинг ашиглана. Үүнд:

- Жин -1 /Ж1/ Аж үйлдвэрт хамаарах салбаруудыг тодорхойлж, тус бүр дээр жинг тооцно. Жинг тооцох үзүүлэлт нь аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээ болон салбар бүрийн үйлдвэрлэлтийн хэмжээ байна.

- Жин-2 /Ж2/ Аж үйлдвэрийн салбар бүрт хамаарах дэд салбарыг тодорхойлж, тус бүр дээр жинг тооцно. Жинг тооцох үзүүлэлт нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтийн хэмжээ болон дэд салбар бүрийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээ байна.

- Жин-3 /Ж3/ Аж үйлдвэрийн салбарын дэд салбар бүрт хамаарах бүтээгдэхүүнийг тодорхойлж, тус бүр дээр жинг тооцно. Жинг тооцох үзүүлэлт нь аж үйлдвэрийн дэд салбарт багтах бүлгүүдийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээ болон тухайн дэд салбарт багтах бүтээгдэхүүн тус бүрийн үйлдвэрлэлтийн хэмжээ байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бүх жингийн нийлбэр нь нэгтэй тэнцүү байна. Аж үйлдвэрийн салбарын бүтцэд гарч буй өөрчлөлтийг тусгах үүднээс салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дүнд үндэслэн жинг жил тутам шинэчилж тооцно. Тухайн оны тооцоонд өмнөх оны жинг ашиглана.

### III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

#### 3.1 Говь–Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил

Аливаа улс орны хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйлийн нэг нь үйлдвэржүүлэлт юм. Монгол Улсын үйлдвэржүүлэлт, түүний эрх зүйн орчны түүхэн хөгжлийг дараах үе шатуудад хуваан авч үзэж болох юм. Үүнд :

- **1921-1960 он.** Үндэсний үйлдвэрлэлийн үндэс суурийг тавьж Мал аж ахуй- Хөдөө аж ахуй-Аж үйлдвэрийн орон болсон үе.
- **1960-1990 он.** Үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлж аж үйлдвэр-ХАА-н орон болох зорилтыг хэрэгжүүлэх үе.
- **1990 оноос хойш.** Зах зээлд шилжих шилжилт, үйлдвэржүүлэлтийн хямрал, үйлдвэржүүлэлтийг сэргээх бодлого, төлөвлөлтийн он жилүүд.

Манай аймгийн хувьд аж үйлдвэрийн салбар нь


**1921-1960 он.** Үндэсний үйлдвэрлэлийн үндэс суурийг тавьж Мал аж ахуй- Хөдөө аж ахуй-Аж үйлдвэрийн орон болсон үе. 1941 онд 2.2 мянган төгрөг, 1950 онд 1549.6 мянган төгрөг, 1960 онд 5282.4 мянган төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж жил бүр аж үйлдвэрийн салбар өссөн өргөжсөөр ирсэн билээ. 1960 онд нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.1 хувийг цахилгаан эрчим хүч, 13.4 хувийг барилгын материал, 9.9 хувийг оёдол, 10.1 хувийг арьс шир, 1.0 хувийг хэвлэл, 41.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 21.3 хувийг бусад үйлдвэрлэл эзлэж байжээ. 1943-1960 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нь гол нэр төрлөөрөө саван, цөцгийн тос, архи дарс, чихэр, талх нарийн боов, хэвлэлийн зүйл, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг байжээ.

Зураг-1

Зураг-2

#### 1990 он

#### 1960 он



**1960-1990 он.** Үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлж аж үйлдвэр-ХАА-н орон болох зорилтыг хэрэгжүүлэх үе. 1960 он гарсаар үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж эхэлсэн ба аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нь гол нэр төрлөөрөө нүүрс, саван, монгол дээл, архи дарс, чихэр, талх нарийн боов, гоймон, амтат ус ундаа, улаан тоосго, блок, хэвлэлийн зүйл, цахилгаан эрчим хүч, дулаан эрчим хүч үйлдвэрлэж эхэлсэн байна.

Энэ онуудад уул уурхайн салбар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь 1990 онд 69.3 мянган тонн нүүрс олборлож, 48.3 мянган Г.кал дулаан үйлдвэрлэсэн нь барилгын салбар хөгжиж эхэлсэнтэй холбоотой.

**1990 оноос хойш.** Зах зээлд шилжих шилжилт, үйлдвэржүүлэлтийн хямрал, үйлдвэржүүлэлтийг сэргээх бодлого, төлөвлөлтийн он жилүүд.


Нутаг орны онцлогоос шалтгаалан мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрүүдийг бий болгоход тохиромжтой юм. Эрдэс түүхий эдийг олборлох, боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд харьцангуй цөөн байлаа.

2010 онд Эрчим хүчний салбарын хувьд Алтай–Улиастай ТӨХК байгуулагдсанаар аймгийн 18 сум гэрэл цахилгааны эх үүсвэртэй болсон. Үүнээс шалтгаалан техник, тоног төхөөрөмж ажиллуулж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэж байна.

Аймгийн эрчим хүчний системийг оновчтой өргөтгөн “Улаанбоом”-ын УЦС-ыг ашиглалтанд оруулаж төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбосноор үйлдвэрлэл хөгжих өргөн боломж нээгдэж байна.

Зураг-4


**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, борлуулалт сая.төгрөгөөр 1940-2018 он**



Эх үүсвэр: Говь-Алтай аймгийн статистикийн хэлтсийн танилцуулаа 1941-2018 он

## ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, улсын дүнд эзлэх хувь /1995-2018 он/

Хувь



Хүснэгт-1

### АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЦ, дэд салбараар /дүнд эзлэх хувь/

	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Бүгд</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	5.5	6.9	5.6	4.5	5.9	7.2	14.2	8.2	8.6	9.4
Нүүрс олборлолт	5.5	6.9	5.6	4.5	5.9	7.2	14.2	8.2	8.6	9.4
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	25.6	20.2	11.8	7.4	11.2	11.7	15.0	12.5	15.3	8.9
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	0.2	0.0	0.0	0.0	0.1	0.2	0.2	0.3	0.0
Үр тарианы гурил үйлдвэрлэл	0.9	0.0	0.0	0.4	0.7	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.2	3.0	2.9	2.2	3.0	2.8	6.7	4.5	8.0	3.0
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	12.7	0.7	3.3	2.0	1.4	1.3	1.7	4.0	2.7	3.4
Нэхмэлийн үйлдвэрлэл	2.9	12.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувцас үйлдвэрлэл	1.0	0.5	0.1	0.0	0.2	0.5	1.1	1.1	1.3	0.3
Арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл	0.9	0.2	0.2	0.3	0.8	0.3	0.6	0.3	0.1	0.0
Модон эдлэл үйлдвэрлэл	2.0	1.5	0.2	0.1	0.1	0.6	0.8	0.3	0.2	0.1
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Төмөр бетон эдлэл үйлдвэрлэл	0.0	0.2	4.0	0.0	0.0	2.9	0.1	0.0	0.0	0.0
Төмрийн үйлдвэрлэл	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.1	0.0
Барилгын материалын үйлдвэр	0.0	0.0	1.1	1.9	4.3	2.8	2.3	1.0	1.8	1.7
Мебель тавилга үйлдвэрлэл	0.4	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад үйлдвэрлэл	0.0	1.6	0.1	0.3	0.8	0.2	1.4	1.0	0.7	0.2
<b>Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж</b>	68.9	73.0	82.6	88.1	82.9	81.2	70.7	79.3	76.1	81.7
Цахилгаан үйлдвэрлэл	33.4	28.7	52.6	61.2	50.0	50.2	25.2	41.3	38.9	35.8
Дулаан үйлдвэрлэл	29.1	39.9	27.2	23.3	29.0	27.0	37.7	32.5	30.3	35.0
Ус ариутгал, усан хангамж	6.3	4.3	2.9	3.7	3.8	3.9	7.8	5.5	6.9	10.8

Хүснэгт-1-ээс харахад нийт үйлдвэрлэлийн дийлэнх хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбар эзлэж байгаа нь 2007 оноос хойш 20.6 хувиар нэмэгдсэн нь цахилгаан дулаан эрчим хүч усан хангамжийн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой.

2018 оны байдлаар энэ салбарын 26.6 хувийг цахиалгаан үйлдвэрлэл, 36.8 хувийг дулаан үйлдвэрлэл, 7.9 хувийг ус ариутгал, усан хангамж эзлэж байна.

Боловсруулах салбар нь нийт үйлдвэрлэлийн 19.2 хувийг эзлэж байгаагийн 10.2 хувийг хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 5.4 хувийг ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/, 1.7 хувийг барилгын материал, 0.3 хувийг хувцас үйлдвэрлэл, 0.4 хувийг мīäíí ýäëýë ¿éëäáúðëýë 0.1 хувийг арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл тус тус эзлэж байна.


**ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ,  
улсын үнийн дүнд эзлэх%, /1995-2018 он/**

	Нүүрс	Цахилгаан эрчим хүч	Дулааны эрчим хүч	Түгээсэн цэвэр ус
1995	0.4	0.3	0.6	0.0
2000	0.4	0.3	0.6	0.3
2001	0.2	0.4	0.7	2.0
2002	0.3	0.4	0.9	0.2
2003	0.4	0.4	0.7	0.2
2004	0.4	0.3	1.0	0.1
2005	0.3	0.2	0.8	0.1
2006	0.2	0.3	0.6	0.2
2007	0.2	0.3	0.9	0.2
2008	0.1	0.3	1.2	0.2
2009	0.1	0.3	1.6	0.1
2010	0.1	0.3	1.6	0.1
2011	0.1	0.6	1.6	0.2
2012	0.1	0.6	1.6	0.2
2013	0.1	0.6	1.6	0.3
2014	0.2	0.5	1.6	0.4
2015	0.1	0.4	1.1	0.3
2016	0.1	0.5	1.0	0.4
2017	0.1	0.7	1.2	0.7
2018	0.1	0.6	1.1	0.4

### Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн улс, бүсэд эзлэх хувиар 2000-2018 он

Он	Улсын дүн	Баруун бүс	Говь-Алтай	Улсад эзлэх хувь	Баруун бүсэд эзлэх хувь
1989	8,331.7	417.8	46.8	0.6	11.2
1990	8,425.4	449.5	51.3	0.6	11.4
1991	14,180.2	730.1	91.2	0.6	12.5
1992	27,717.0	1,016.5	88.4	0.3	8.7
1993	156,358.2	3,513.4	603.8	0.4	17.2
1994	233,288.8	5,531.8	439.5	0.2	7.9
1995	296,756.4	5,750.7	750.6	0.3	13.1
1996	314,422.8	5,898.6	1,036.3	0.3	17.6
1997	458,722.4	5,758.7	1,104.7	0.2	19.2
1998	439,954.3	5,248.2	930.3	0.2	17.7
1999	480,511.2	6,816.8	1,557.7	0.3	22.9
2000	574,162.5	10,069.9	1,338.4	0.2	13.3
2001	624,235.2	10,870.0	1,546.0	0.2	14.2
2002	677,859.4	10,643.9	1,626.2	0.2	15.3
2003	793,174.8	11,072.5	2,672.9	0.3	24.1
2004	1175,913.2	11,674.3	3,004.2	0.3	25.7
2005	1463,318.0	12,692.9	2,476.3	0.2	19.5
2006	2092,957.6	12,648.7	2,413.7	0.1	19.1
2007	2590,282.2	14,933.8	2,948.1	0.1	19.7
2008	2877,288.0	18,765.7	6,152.5	0.2	32.8
2009	3073,518.9	23,996.3	5,059.1	0.2	21.1
2010	4456,143.5	30,542.4	5,711.7	0.1	18.7
2011	5596,520.3	32,935.9	5,387.7	0.1	16.4
2012	6224,123.4	30,521.5	6,040.3	0.1	19.8
2013	6661,118.6	31,844.9	7,104.4	0.1	22.3
2014	11107,988.1	47,713.9	13,825.4	0.1	29.0
2015	9998,104.0	157,449.8	6,792.6	0.1	4.3
2016	11067,028.4	154,527.3	6,437.5	0.1	4.2
2017	15160,742.7	299,350.0	7,544.8	0.05	2.5
2018	18297,461.2	405,038.3	11,105.0	0.1	2.7




### Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн улсад эзлэх хувь, бүсэд эзлэх хувиар 2000-2018 он



### 3.3 Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбар

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Хүснэгт-4





### 3.5 Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт ДНБ-д өсөлтөд үзүүлж буй нөлөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт чухал үүрэгтэй билээ. Манай аймгийн аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг дараах тооцооноос харъя.

Говь-Алтай ДНБ (сая.төг)

хүснэгт-5

	2010	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт ДНБ, оны үнээр	65977.1	164803.4	219617.4	237123.9	247561.4	266127.3	311,330.40
АҮ, барилгын салбарын эзлэх хувь	30.9	10.1	13.0	10.2	7.5	6.5	10.9

2010 онд аймгийн ДНБ-ний 2.3 хувийг аж үйлдвэрийн салбар эзэлж байсан бол 2017 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 23.0 хувьд хүрч 10 дахин өссөн байна.

### 3.6 Говь-Алтай аймгийн аж үйлдвэрийн салбар ба барилгын салбарын хамаарлын эконометрикс загварын үнэлгээ

Аж үйлдвэрийн салбарын хөгжил нь нийгмийн олон үзүүлэлттэй уялдаа холбоотой байдаг ба тэр дундаас барилгын салбарын хөгжилтэй илүү уялдаа холбоотой байдаг боловч гэдэг үүднээс барилгын салбарын өсөлт бууралт энэ салбарт хэрхэн нөлөөлж байгааг судалж үзье. Илүү үнэн зөв бодитой харагдуулах зорилгоор нийт барилга угсралт их засварын ажлыг нэгтгэж авлаа.

Манай аймгийн хувьд 2006 оноос эхлэн Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд төслүүд хэрэгжин хувийн орон сууц нэмэгдсэн ба 2006-2008 оны хооронд 2 шинэ хороолол нэмэгдэн гарч үүний хүрээнд нийт 162 орон сууц ашиглалтад орсон билээ. Сүүлийн 3 жилийн хугацаанд барилгын салбарын


өсөлтөд энэ үзүүлэлт нь чухал байр суурь эзэлнэ. 2017 онд барилгын салбар 9 тэрбум 861.9 сая төгрөг ажил гүйцэтгэсэн байна.

2017 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 268474.1 сая төгрөг хүрч баруун бүсийн 17.5 хувь, улсын дүнд 0.9 хувийг эзэлж байна.


**13.6 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, салбараар, оны үнээр**  
**GROSS DOMESTIC PRODUCT by region, aimag and the capital, by division, at current prices**

	2017				2018*			
	Дүнд эзлэх хувь Share to total				Дүнд эзлэх хувь Share to total			
	ДНБ, сая төгрөг GDP, million togrogs	Хөдө ө аж ахуй Agric ulture	Аж үйлдвэр, барилг а Industr y, constru ction	Үйлчил гээ Service s	ДНБ, сая төгрөг GDP, million togrogs	Хөдө ө аж ахуй Agric ulture	Аж үйлдвэр, барилга Industr y, constru ction	Үйлчи лгээ Service s
<b>Улсын дүн</b>	<b>27 876 297.2</b>	<b>10.1</b>	<b>41.4</b>	<b>48.5</b>	<b>32 093 615.4</b>	<b>10.8</b>	<b>41.6</b>	<b>47.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>1 549 701.8</b>	<b>39.9</b>	<b>19.5</b>	<b>40.6</b>	<b>1 798 155.8</b>	<b>42.5</b>	<b>20.9</b>	<b>36.7</b>
Баян-Өлгий	326 833.6	35.3	18.0	46.8	368 120.7	37.9	18.5	43.6
Говь-Алтай	266 127.3	45.8	22.9	31.3	311 330.4	48.8	23.0	28.3
Завхан	311 609.3	44.2	13.2	42.6	346 754.8	46.9	13.3	39.8
Увс	318 877.8	35.0	24.5	40.5	384 768.3	40.4	24.2	35.4
Ховд	326 253.8	40.3	19.7	40.1	387 181.5	39.8	24.9	35.3


**Аймгийн ДНБ-д  
салбаруудын эзлэх хувь  
2017 он**



**Аймгийн ДНБ-д  
салбаруудын эзлэх хувь  
2018 он**



**Барилгын салбарын гүйцэтгэл /мян.төг/**



Аймгийн хэмжээний нийт орон сууцны тоо жилээс жилд тогтмол өсөж байгаа нь иргэд дулаан тохилог орон сууцанд амьрах хүсэл зорилго ихтэй иргдийн амьжиргаа нь сайжирч байгаатай холбоотой юм. 2016 онд барилга угсралт, их засвар 2015 оноос 7 дахин өссөн нь Алтай- Ховд чиглэлийн замын ажил баригдаж дууссантай холбоотой байна.

Аж үйлдвэр, барилга угсралт гэсэн 2 үзүүлэлт нь хоорондоо хамааралтай эсэхийг SUMMARY OUTPUT

<i>Regression Statistics</i>	
Multiple R	0.453
R Square	0.206
Adjusted R Square	0.153
Standard Error	4471.195
Observations	17.000

ANOVA

	<i>df</i>	<i>SS</i>	<i>MS</i>	<i>F</i>	<i>Significance F</i>
Regression	1	77611140.32	77611140.32	3.88219	0.067547721
Residual	15	299873811.5	19991587.43		
Total	16	377484951.8			

	<i>Coefficients</i>	<i>Standard Error</i>	<i>t Stat</i>	<i>P-value</i>	<i>Lower 95%</i>	<i>Upper 95%</i>	<i>Lower 95.0%</i>	<i>Upper 95.0%</i>
Intercept	6398.472363	1188.632	5.383	0.000	3864.962	8931.982	3864.962	8931.982
Y	0.072813944	0.037	1.970	0.068	-0.006	0.152	-0.006	0.152

Үүнээс харахад барилга угсралтын ажил 1 хувиар өсөхөд аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн индекс 0,07 хувиар өссөн байна гэж харагдаж байна. Гарсан үр дүнгээс харахад детерминацийн коэффициент 20,6 хувь байгаа нь эдгээр хувьсагч тайлбарлагдах чадвартай гэж үзэж байна. Multiple R 0,453 хоорондоо хүчтэй хамааралтай. Түүнчлэн t-statistic нь модулиар ойролцоогоор 2-оос их. Prob буюу магадлал нь 0.05-аас бага байвал ач холбогдолтой гэж үздэг ба манай судалгаан дээр бүх хувьсагчид ач холбогдолтой байна. Ийм учраас барилга угсралтын ажилаас шууд хамааралтайгаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт шаалтгаална гэж үзлээ.

Аж үйлдвэрийн салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлохын тулд нийт бүтээгдэхүүнд хийсэн динамикийн шинжилгээ хийлээ.

2000-2016 он хүртэлх нийт үйлдвэрлэлтийн хэмжээг динамикийн аргаар урьдчилан тооцоолъё.

2000-2016 он хүртэлх нийт үйлдвэрлэлтийн хэмжээг динамикийн аргаар урьдчилан тооцоолъё.

n	Он	Нийт бүтээгдэхүүн /y/	t	t <sup>2</sup>	y*t
1	2000	1987.6	-8	64	-15900.7
2	2001	2136.3	-7	49	-14953.8
3	2002	2407.2	-6	36	-14443.0
4	2003	2515.0	-5	25	-12575.0
5	2004	2855.1	-4	16	-11420.3
6	2005	2690.5	-3	9	-8071.6
7	2006	2877.1	-2	4	-5800.1
8	2007	6779.9	-1	1	-6779.9
9	2008	6537.7	0	0	0.0
10	2009	5577.9	1	1	5578.0
11	2010	11253.3	2	4	22506.7
12	2011	13870.8	3	9	41612.6
13	2012	12096.4	4	16	48385.6
14	2013	13938.4	5	25	69691.8
15	2014	10818.4	6	36	64910.4
16	2015	11735.5	7	49	94419.3
17	2016	13488.5	8	64	105784.7
<b>Total</b>		125076.1		408	362944.6


Шулуун шугамын тэгшитгэл ашиглан прогноз хийвэл:

$$\begin{cases} 17a_0 + 0 * a_1 = 125076.1 \\ 0 * a_0 + 408a_1 = 362944.6 \end{cases}$$

Эндээс:  $a_0 = 7357.4$   $a_1 = 889.6$  гэж гарч байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тэгшитгэлээ бичвэл  $y_t = 7357.4 + 889.6 t$  гэвэл

$y_{2017} = 7357.4 + 889.6 * 9 = 15363.8$  болох юм.  $y_{2018} = 16253.4$   $y_{2019} = 17143$  буюу жилд 1.06 дундаж хурдтайгаар өснө гэсэн тооцоо гарч байна.



Мөн үүний адил борлуулалтад шинжилгээ хийж үзвэл:

n	Он	Нийт бүтээгдэхүүний борлуулалт /y/	t	t <sup>2</sup>	y*t
1	2000	1609.3	-8	64	-12874.4
2	2001	1876.9	-7	49	-13138.3
3	2002	2027.7	-6	36	-12166.2
4	2003	2232.7	-5	25	-11163.3
5	2004	2891.9	-4	16	-11567.8
6	2005	2710.4	-3	9	-8131.23
7	2006	2877.1	-2	4	-5754.15
8	2007	3496.7	-1	1	-3496.7
9	2008	6850.8	0	0	0
10	2009	5673.1	1	1	5673.146
11	2010	6763.2	2	4	13526.4
12	2011	7372.5	3	9	22117.59
13	2012	8471.5	4	16	33886
14	2013	10210.6	5	25	51053.15
15	2014	10372.8	6	36	62236.63
16	2015	11561.6	7	49	80931.07
17	2016	11466.1	8	64	91728.6
<b>Total</b>		98464.9		408	282860.5

Эндээс шугаман регрессийн тэгшитгэл бичвэл:


$$a_0 = \sum \frac{y}{n} = \frac{98464.9}{17} = 5792.0 \quad a_1 = \frac{\sum y*t}{t^2} = \frac{282860.5}{408} = 693.3$$

$$y = 5792.0 + 693.3 t$$

Энэ тэгшитгэлийг ашиглан дараагийн 3 жилийн прогнозыг гаргая.

$$y_{2017} = 12031.7 \quad y_{2018} = 12725 \quad y_{2019} = 13418.3$$

### Бүтээгдэхүүн



#### IV. ДҮГНЭЛТ

Нийт үйлдвэрлэлийн өсөлтийн дийлэнх хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбар эзлэж байгаа нь 2007 оноос хойш 2.1 дахин нэмэгдсэн нь цахилгаан, дулаан эрчим хүч, ариутгал усан хангамж үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой. 2018 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын 71.2 хувийг цахилгаан, дулаан үйлдвэрлэл, ариутгал усан хангамж , 19.2 хувийг боловсруулах үйлдвэр, 9.6 хувийг уул уурхай эзлэж байна.

Манай аймгийн хувьд уул уурхайн салбар нь 1970 оноос хойш хүрэн нүүрс олборлож эхэлсэн Гоби-Голд, Мандал Хүдэр ХХК-ууд нь 44 ажиллсагсадтайгаар 2018 онд 26.5 мянган тонн нүүрс үйлдвэрлэн аймгийнхаа хэрэгцээг хангаж байна.

Цахилгаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын хувьд сүүлийн 3 жилийн байдлаар үйлвэрлэлт нь огцом өссөн нь хэрэгцээ байгааг харуулж байна. Энэ нь Алтай-Улиастай эрчим хүчний төв систем байгуулагдаж төвийн бүсийн эрчим хүчний системүүдтэй холбогдон үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн өсөлтөнд Есөнбулаг сумын нийт бүтээгдэхүүний өсөлт шууд нөлөөлсөн байна. 2015 онд сумдын нийт дүнд эзлэх хувиас харахад тус салбарын нийт бүтээгдэхүүний Есөнбулаг 88,1 хувийг, Дарив 1,4 хувийг, Тайшир 1,4 хувийг, Чандмана 1.1 хувийг, Бугат 1,1 хувийг Эрдэнэ 0,9 хувийг эзлэж байгаа нь эдгээр сумдад үйлдвэрлэл илүү хөгжиж байгааг харуулж байгаа ба үлдсэн 6 хувийг бусад сумд эзлэж байна.

## **Барилгын салбарын цаашдын хөгжлийн чиг хандлага хууль эрх зүйн байдал**

- ...Хот байгуулалтын тухай хууль
- ...Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- ...Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- ...Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
- ...Орон сууцны тухай хууль
- ...Барилгын тухай хууль
- ...Газрын тухай багц хууль

### ***Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Шинэчилсэн найруулга:***

- Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай
- Хот байгуулалтын тухай
- Барилгын тухай

### ***Нэмэлт өөрчлөлт:***

- Геодези, зураг зүйн тухай хууль
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай
- Орон сууц хувьчлах тухай

### ***Шинээр:***

- Газар албадан чөлөөлөх тухай
- Хотыг дахин хөгжүүлэх тухай
- Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай
- Авто зогсоолын тухай
- Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн тухай

### ***Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030***

**Зорилт 4.** Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

**I үе шат (2016-2020):** Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.

**II үе шат (2021-2025):** Жилд 100.0 мянган тонн ган туйван, барилгын болон төмөр замын металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулах.

**III үе шат (2026-2030):** Төмөр, ган, хайлшийн бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх.

**Зорилт 6.** Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл,

**аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.

**II үе шат (2021-2025):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг хот, суурин газруудад хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулах.

**III үе шат (2026-2030):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот, суурин газруудыг хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 40 хувиар бууруулах.

**Зорилт 7. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.**

**I үе шат (2016-2020):** Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.

**II үе шат (2021-2025):** Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.

## **2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах макро эдийн засаг, салбарын хөгжлийн бодлого нь дараахь суурь зарчимд тулгуурлана:

### **Аймгийн товч мэдээлэл**

Баруун бүсийн 5 аймаг нь нийтдээ 91 сумтай, 476 баг хороотой нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 415.3 мянган км квадрат ба хүн амын нягтшил 0.9 хүн нэг кв.км-т байгаа нь бусад бүсүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад дундаж байна.

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ 141.4 мянган км квадрат ба хүн амын нягтшил 0.4 хүн нэг кв.км-т байгаа нь бусад аймаг, хотуудтай

харьцуулахад хамгийн бага байна.

Харин төвийн бүс болон Улаанбаатар нийслэлээсээ Баян-Өлгий аймаг 1709 км, Говь-Алтай аймаг 1037 км, Завхан аймаг 1023 км, Ховд аймаг 1487 км, Увс аймаг 1417 км хол оршдог.

Бусад бүсээс ялгаатай нь говь, хангай хосолсон өргөн уудам нутагтай далайн түвшингөөс дээш 721-4070 метр өндөрт, газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог.

Говь-Алтай аймаг зүүн талаараа Баянхонгор, хойд талаараа Завхан, Ховд өмнөд талаараа БНХАУ-тай хил залган оршино.

Аймгийн БНХАУ-тай хиллэдэг хилийн урт 360 км болж тэдгээр нь хилийн 128-171 дүгээр тэмдгээр тэмдэглэгджээ. Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэр 141.4 мянган хавтгай дөрвөлжин км улсдаа газар нутгийн хэмжээгээр хоёрт ордог.

Дэлхийн цагийн 6 дугаар бүсэд байрладаг, уул, тал, хөндий, уужим говь, тавиун хотгор, хонхор хосолсон газрын гадаргуутай.

Аймгийн нутаг дэвсгэр нь газрын дүрс мужлалын хувьд алтайн уулархаг их муж, говийн их мужид хамаарах бөгөөд байгалийн бүс, бүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэд оршино. Мөн бага хэмжээгээр хээр тал болон өндөр уулсын босоо буюу тагийн бүслүүр тархсан байдаг.

Шилжилт хөдөлгөөн нийслэлд төвлөрөх хандлагатай болж Улаанбаатар хот хүн амын нягтралаараа хамгийн өндөр буюу нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2010 онд 246 хүн ноогдож байсан бол 2017 онд 306.5 болж, 19.7 хувиар өсчээ.

2017 оны байдлаар Улаанбаатар хот Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа нийт хүн амын 46.0 хувь нь оршин сууж байгаа төдийгүй энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

### МОНГОЛ УЛСЫН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2015 ОН



2015 оны орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 45.4 хувь нь үндэсний уламжлалт сууц гэрт, 54.2 хувь нь байшинд, 0.4 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын мөн үеийнхээс 0.2 пунктээр, байшинд амьдардаг өрхийн хувь 0.6 пунктээр нэмэгджээ.

### Аймгийн барилгын салбарын түүх

Монгол улсад барилгын салбар 1921 онд Аж ахуйн явдлын яам, Харилцан туслалцах хоршоолол, Монгол банкыг түшиглүүлэн Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоог нэг буман төгрөгийн хөрөнгөтэйгээр байгуулсан нь Монгол улсад барилгын байгууллагын үүсэл болсон түүхтэй.

Барилгын хувь нийлүүлсэн хоршоо байгуулагдсан анхны жилдээ 760 гаруй мянган төгрөгийн төлөвлөгөө улсаас авч ажилласан байна.

Барилгын салбар тасралтгүй хөгжиж тэргүүн эгнээний салбар, бүх ард түмний үйл хэрэг болж байжээ.

Улсын хэмжээгээр гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын хэмжээ 1986-1990 онд жилд дунджаар 100 гаруй тэрбум төгрөгт хүрч байжээ.

Барилгын салбарын оргил үе гэж хэлж болох 1989 оны байдлаар одоогийн үнийн ханшаар 100 гаруй тэрбум төгрөгийн өртөг бүхий машин механизм ашиглагдаж, салбарын үндсэн хөрөнгийн 50 гаруй хувийг эзлэн, нэг төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд 48 мөнгөний зардал гаргаж байжээ. Энэ үед газар шорооны ажлын 92.8-93.4 ачиж буулгах ажлын 78.4-87.6, бетон, бетон төмөр хийц бүтээж угсрах ажлын 77.6-85.3 хувийг механикжсан аргаар гүйцэтгэж, жил тутам паркийн 5-10 хувийг дэс дараатайгаар шинэчилж байв.

Говь-Алтай аймгийн хувьд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1958 оны 3 дугаар сарын 15-нд Шарга сумын төвд 100 гаруй ажилчид, 13 инженер техникийн ажилтан, 17 авто машин бүхий Хөдөө аж ахуйн барилгын ангийг байгуулж ажилуулсан нь барилгын байгууллагын үүсэл болсон юм.

Энэхүү барилгын анги нь Шарга сумын Мал аж ахуйн машинт станцыг барихаар 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, жилдээ 2.2 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй байсан байна. Шарга сумын төвд байсан барилгын анги нь 1959 онд Цагаан-Оломд нүүж очоод, 1960 онд хоёр хуваагдан нэг хэсэг нь Завханд шилжиж, нөгөө хэсэг нь Говь-Алтай аймгийн төвд ирж төвлөрсөн түүхтэй.

Манай аймгийн барилгачид 1960-1970 онд Алтай хотод арван жилийн 5-р сургууль, Халуун ус, Спортын заал, 24 айлын орон сууц, Тоосгоны заводын барилга, 1970-1980 онд аймгийн Холбооны газар, Усны аж ахуйн контор, Үйлдвэрлэлийн байр, Модны үйлдвэр, 27, 36 айлын орон сууц, Халдвартын больниц, 160 ортой нэгдсэн эмнэлэг, Сутай зоогийн газар, Хөргүүртэй махны зорь, Хүнсний үйлдвэр, Дизель цахилгаан станцын 1.2-р өргөтгөл, АУДУС-ийн барилга, 1980-1990 онд Барилга үйлдвэрлэлийн бааз, 36 айлын гурван ширхэг орон сууц, арван жилийн 3-р сургууль, 280 ортой цэцэрлэг, дизель цахилгаан станцын 3,4-р өргөтгөл, аймгийн намын хороо, Цагдаагийн хэлтэс, Банкны нэгдсэн контор, ХАА-н ТМС, АУК-ын Дотуур байр зэрэг олон арван томоохон барилга байгууламж, үйлдвэр аж ахуйн газруудыг барьж байгуулсны дээр дээрх хугацаанд сумдад сургууль, эмнэлэг, цэцэрлэг, ясли, соёл, үйлчилгээний олон арван барилгуудыг барьж ашиглалтанд оруулсан юм.

Зах зээлийн шилжилтийн жилүүдэд хөрөнгө оруулалт үндсэндээ хийгдэхгүй барилгын ажил зогсонги байдалд орсон боловч 1995-1996 оноос эхлэн бага багаар сэргэж, одоо хөгжих шатандаа орлоо. 1995 онд манай аймагт Хилийн худалдааны үйлчилгээний төв, хүнсний цех, скалад, худаг зэрэг шинэ барилга, Номын сан, даатгалын салбар, ясли, 160 ортой нэгдсэн эмнэлэг, ХАА-н бирж зэрэг газруудын их засварууд хийгдэж байжээ.

Аймгийн хэмжээнд солонго хороололд 120 өрх шинэ орон сууцанд амьдрах боломжтой болно. 2016 оны байдлаар аймгийн төв болон сумдад 36 орон сууцанд айл өрхүүд шинэ орон сууцандаа орсон байна. Хувийн орон сууц сүүлийн жилүүдэд өсөж байгаа хэдий ч цахилгаан, дулаан, усны хүрэлцээ муугаас иргэд ая тухтай сайхан амьдархад хүндрэлтэй байна..

**Засаг захиргааны нэгж, тэдгээрийн нутаг дэвсгэр, урт  
Хүснэгт 1.1 Засаг захиргааны нэгж 2018 онд**

№	Сумын нэр	Сумын төвийн баг	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ км <sup>2</sup>	Алслалт километр Улаанбаатар-аас	Аймгийн төвөөс
	<b>БҮГД</b>		<b>87</b>	<b>141447</b>	-	-
1	Алтай	Баян овоо	4	20256	1319	318
2	Баян-Уул	-	6	5836	1112	146
3	Бигэр	-	5	3826	961	108
4	Бугат	Баян гол	5	9921	1204	219
5	Дарив	Үйлдвэр	4	3523	1187	212
6	Дэлгэр	Баянсан	5	6625	913	88
7	Жаргалан	-	3	3683	1047	102
8	Тайшир	-	3	3913	991	43
9	Тонхил	-	5	7322	1210	218
10	Төгрөг	-	5	5343	1149	148
11	Халиун	-	4	5214	1056	87
12	Хөхморьт	Сайн уст	5	6314	1182	215
13	Цогт	-	7	16618	1040	187
14	Цээл	Баянгол	4	5631	1136	167
15	Чандмана	-	4	4629	955	189
16	Шарга	Баянгол	4	5566	1080	79
17	Эрдэнэ	-	4	25066	989	223
18	Есөнбулаг	-	10	2161	1037	-

**Хүснэгт 1.2 Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарь**

	Хэмжээ
Нутаг дэвсгэр /мян.км <sup>2</sup> /	141.4
Хилийн урт /км/	2040
Өмнөт цэгээс хойд цэг хүртэлх зай /км/	638
Баруун цэгээс зүүн цэг хүртэлх зай /км/	413
Монгол улсын нийт нутаг дэвсгэр /мян.км <sup>2</sup> /	1564.9
Монгол улсын нэг аймагт ноогдох нутаг дэвсгэрийн дундаж /мян.км <sup>2</sup> /	74.3
Баруун бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээ /мян.км <sup>2</sup> /	415.3
Баруун бүсийн аймгуудын нутаг дэвсгэрийн дундаж хэмжээ /мян.км <sup>2</sup> /	83.1
Өмнөговь аймаг хамгийн том нутаг дэвсгэртэй /мян.км <sup>2</sup> /	165.2
Орхон аймаг хамгийн бага нутаг дэвсгэртэй /мян.км <sup>2</sup> /	0.8
Говь-Алтай аймаг улсад нутаг дэвсгэрээрээ II байранд орж байна	
Монгол улс дэлхийд нутаг дэвсгэрээрээ XVII байранд ордог	

### Хүснэгт 1.3 Говь-Алтай аймгийн хамгийн өндөр, нам цэг

	Цэгийн нэр	Физик газар зүйн бүсийн нэр	Тухай цэгийн байршил	
			Оршдог сумын нэр	Өндөр, нам далайн түвшнээс дээш метр/
Хамгийн өндөр цэг	Сутай уул	Монгол Алтайн нуруу	Тонхил Дарив	4090
Хамгийн нам цэг	Загт их сайрын хонхор	Цэнхэр Номингийн говь	Цогт	721
Үнэмлэхүй дундаж өндөр				2405.5
Монгол улсын хамгийн өндөр цэг	Хүйтний оргил	Монгол Алтайн нуруу	Баян-Өлгий аймаг Цэнгэл сум	4374
Монгол улсын хамгийн нам цэг	Хөх нуурын хотгор	Хөх нуурын хотгор	Дорнод аймаг	532

### Аймгийн дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн байдал /Цахилгаан эрчим хүчний хангамж/

Алтай-Улиастай ТӨХК-ийн 8 дизель станц, Тайшир гуулин усан цахилгаан станцтай зэрэгцээ ажиллагааны горимоор ажиллаж байна. Мөн цахилгаан эрчим хүч дутагдвал төвийн бүсийн нэгдсэн системээс цахилгаан эрчим хүч авч аймгийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Алтай сум, Бугат сумын Тахийн тал, Цогт сумын Баянтоорой тосгоныг нарны цахилгаан эрчим хүч, наргүй өдөр дизель станцаар зэргээр ханган ажиллаж байна.

#### Дулаан хангамж

Алтай хотод хувийн 3 аж ахуйн нэгж төвлөрсөн дулаан хангамжийн үйл ажиллагаа явуулж, түүнээс “Мандал-Голомт” ХХК нь нэгдсэн халаалтын 56мВт хүчин чадал бүхий 3 зуухтай бөгөөд аймгийн төвийн 150 аж ахуйн нэгж албан байгууллага 1143 айл өрхөд дулаан түгээх хангах үйл ажиллагаа явуулж байна.

Дарив, Эрдэнэ, Тайшир сумдын дулааны хувийн аж ахуйн нэгж /24 өрх, 17 ААНБ/ хэрэглэгчдийг нэгдсэн дулаан хангамжийн систем бүхий уурын зуухаар, бусад 14 сумын төвийн аж ахуйн нэгж албан байгууллагууд нам даралтын уурын зуухаар дулааны эрчим хүчний асуудлаа шийдвэрлэж байна.

Мөн Алтай хотод шинээр дулааны станц, Бигэр сумын төвийг төвлөрсөн дулааны системд холбохоор төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барихаар төлөвлөн ажиллаж байна.

#### /Тээвэр, холбоо/

Аймгийн хэмжээнд орон нутгийн чанартай нийт 3453.4 км авто зам байдгаас асфальто, бетон хучилттай авто зам 309 км улсын чиглэл, 18 км орон нутгийн зам, сайжруулсан хөрсөн хучилттай 99.7 км, хайрган хучилттай 183.6 км, хөрсөн буюу шороон зам 3154.8 км авто зам байна.

Жил бүрийн орон нутгийн замын сангийн хөрөнгөөр дээрх замуудад засвар, арчлалтын ажлыг ээлж дараатай хийж байна. Мөн Бигэр сумын Өөшийн

27.8 км замын зураг төсөв, Алтай хотын Жаргалант багийн 2.2 км хатуу хучилттай автозамын зураг төсөв, шинээр барих 1.4 км автозам, зогсоолын ажлын зураг төсөв, Хөгжил хорооллын хатуу хучилттай авто замын зураг төсвийг хийлгэж бэлэн болгосон байна.

Алтай-Баянхонгор чиглэлийн улсын чанартай 128 км, Алтай-Ховд чиглэлийн улсын чанартай 165 км хатуу хучилттай авто замыг ашиглаж байна. Хувийн хөрөнгө оруулалтаар Таяннуурын уурхай /Алтайн хүдэр/-Бургастай боомт чиглэлийн 168.3 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг гүйцэтгүүлж байна.

Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг “Аяны зам-Алтай” хоршоо, “Бид анд” ХХК-ний гэрээт жолооч нар Алтай-Улаанбаатар-Алтай чиглэлд үзүүлж байна.

### **Алтай-Баянхонгор чиглэлийн /128 км/ засмал зам**



### **Алтай-Ховд чиглэлийн 165 /км/ зам**



**Улс, бүс, аймгийн дотоодын  
барилга угсралт, зам, бусад их засвар**

**Улс, бүс, аймгийн барилга, их засварын ажил /сая төгрөгөөр/**

он	2007	2010	2015	2016	2017	2018*
Говь-Алтай аймаг	1853.8	14839.6	17093.8	128454.7	9861.9	22847.4
Баруун бүс	17873.5	52862.8	171620.9	196269.1	158498.4	93964.5
Монгол улс	364404.4	442743.9	2290540.3	3282737.9	3669436.9	729528.8
Баруун бүсэд эзлэх хувь	<b>10.37</b>	<b>28.07</b>	<b>9.96</b>	<b>65.45</b>	<b>6.22</b>	<b>24.31</b>
Монгол улсад эзлэх хувь	<b>0.51</b>	<b>3.35</b>	<b>0.75</b>	<b>3.91</b>	<b>0.27</b>	<b>3.13</b>

\* Урьдчилсан гүйцэтгэл


**Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил  
бүсээр /сая төгрөгөөр/**

Аймаг	2010	2015	2016	2017	2018
Баян-Өлгий	7536.0	16886.1	6759.7	27469.4	35152.8
Говь-Алтай	14839.6	16915.8	128454.7	9861.9	22847.4
Завхан	3977.7	43474.7	26113.1	104971.1	161954.1
Увс	7697.8	60908.4	38454.4	27408.7	35294.1
Ховд	18811.7	33477.9	41698.2	35329.2	41973.7
<b>Дүн</b>	<b>52862.8</b>	<b>171662.9</b>	<b>241480.1</b>	<b>205040.3</b>	<b>297222.1</b>

**Барилгын байгууллагын гүйцэтгэл баруун бүсэд эзлэх хувь аймгаар**


Аймаг	2010	2015	2016	2017	2018
Баян-Өлгий	14.3	9.8	2.8	13.4	11.8
Говь-Алтай	28.1	9.9	53.2	4.8	7.7
Завхан	7.5	25.3	10.8	51.2	54.5
Увс	14.6	35.5	15.9	13.4	11.9
Ховд	35.6	19.5	17.3	17.2	14.1
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

**Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн  
барилга угсралт, их засварын ажил аймгаар /сая.төг/**



	1990	2006	2007	2008	2009	2010	2015	2016	2017	2018
Óëààí òííñàí /lÿí.ø/	.	575	537.5	1060	2276.8	1098	425.0	704.0	669.5	380.5
Áëíë /lÿí.ø/	423.2	.	10.4	206	.	.	190.5	74.7	50.9	9.6
Õààààí òííñàí /lÿí.ø/	4069.2	114	153	192	.	.	.	.	.	.
Øííáëéí òëë /lÿí.ø/	.	.	1.4	2.5	.	.	.	.	.	0.6

**Барилгын материал үйлдвэрлэл**



Сүүлийн жилүүдэд улаан тоосго, блок, шонгийн хөл, хуванцар цонх, модон хаалганы үйлдвэрлэл буурч байна.

Дагуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Барилга барих газрын нөөц ихтэй</li> <li>Улсын баруун бүсийн төв зам дайрч өнгөрдөг</li> <li>Ажиллах хүчний нөөц сайтай</li> <li>Холбоо, мэдээллийн технологи сайн хөгжсөн</li> <li>Инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй</li> <li>9 баллын газар хөдлөл даах тэсвэртэй төмөр бетон карказан барилга барих боломжтой</li> <li>Эрдэс баялаг, ашигт малтмалын нөөц ихтэй Түүхий эд материал үйлдвэрлэх, байгалийн материал элбэг /элс, хайрага/</li> <li>Барилгын кампанийн хүрэлцээтэй</li> <li>Олон улсын нислэг хийх буудал баригдаж байгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цэвэр усны нөөц ховор /Усны хатуулаг их/</li> <li>Дулааны хангамж хүрэлцээ муутай.</li> <li>Цахилгаан эрчим хүч хүрэлцээгүй, төвийн эрчим хүчинд холбогдоогүй.</li> <li>Газар хөдлөлийн идэвхитэй бүс</li> <li>Барилгын материалын үнэ өндөр</li> <li>Төвлөрсөн зах зээлээс алслагдсан</li> <li>Байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай</li> <li>Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил сул</li> <li>Хотын тохижилт хангалтгүй</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Эрсдэл, аюул</b>
<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн түгээмэл тархацтай түүхий эд материал элбэг түүнийг түшиглэж барилгын материалын үйлдвэр барих</li> <li>Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх</li> <li>Аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид олонтой</li> <li>Банк, санхүү, төслийн байгууллагуудын дэмжлэг авах боломжтой</li> <li>Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй</li> <li>Олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газар хөдлөлийн идэвхтэй бүсэд оршдог</li> <li>Иргэдийн орлогын эх үүсвэр бага</li> <li>Эдийн засгийн хямрал</li> <li>Дэлхийн цаг агаарын өөрчлөлт</li> <li>Гүний болон гадаргын усны нөөц хомсдох</li> <li>Хүн малын халдварт өвчин гарах</li> </ul>

**Говь-Алтай аймгийн томоохон бүтээн байгуулалт  
Тайширын сум дахь усан цахилгаан станц**



**Байршил:** Говь-Алтай аймгийн Тайшир сумын Улаанбоомын хавцал

**Ашиглалтанд орсон хугацаа:** 2008

**Төслийн хүчин чадал:** 11 МВт, 37 сач кВт цаг

**Хөрөнгийн эх үүсвэр:** Кувейтын Сангаас 6.5 сая кувейт динар (20,0 орчим сая ам.доллар), Абу Даби Сангаас 47.7 сая эмират дирхам (13.0 орчим сая ам.доллар) зээлийн хэлэлцээрүүд байгуулагдсан.

**Говь-Алтай аймгийн томоохон барилга “Ардын дуу бужгийн Алтай чуулга”**



**Байршил:** Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум  
**Ашиглалтанд орсон хугацаа:** 2015 он  
**Төслийн хүчин чадал:** 550 хүний суудалтай  
**Хөрөнгийн эх үүсвэр:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

### Өрхийн тоо, сууцний төрөл, хот, хөдөө, хувиар 2010 он

Сууцны төрөл	Бүгд		Аймаг		Сум		Тосгон		Хөдөө	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>14562</b>	<b>100</b>	<b>4425</b>	<b>100</b>	<b>4011</b>	<b>100</b>	<b>405</b>	<b>100</b>	<b>5721</b>	<b>100</b>
Гэр	12152	83.5	2984	67.4	3203	79.9	304	75.1	5661	99
Байшин	2324	16	1429	32.3	740	18.4	100	24.7	55	1.0
Зориулалтын бус сууц	86	0.6	12	0.3	68	1.7	1	0.2	5	0.1
Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	0

### Хүснэгт 14.1 Өрхийн тоо, сууцны төрлөөр

Сууцны төрөл	2000		2010	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>14796</b>	<b>100</b>	<b>14562</b>	<b>100.0</b>
Гэр	13160	88.9	12152	83.5
Зориулалтын бус сууц	0	0.0	86	0.6
Бусад	0	0.0	0	0.0
Байшин	1636	11.1	2324	16.0
Орон сууцны байшин	239	14.6	586	25.2
Бие даасан тохилог сууц <sup>1</sup>	-	-	115	4.9
Сууцны тусдаа байшин	908	55.5	1436	61.8
Нийтийн байр <sup>2</sup>	489	29.9	187	8.0

### Хүснэгт 14.2 Өрхийн тоо, сууцний төрөл, хот, хөдөө, хувиар 2010 он

Сууцны төрөл	Бүгд		Аймаг		Сум		Тосгон		Хөдөө	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>14562</b>	<b>100</b>	<b>4425</b>	<b>100</b>	<b>4011</b>	<b>100</b>	<b>405</b>	<b>100</b>	<b>5721</b>	<b>100</b>
Гэр	12152	83.5	2984	67.4	3203	79.9	304	75.1	5661	99.0
Байшин	2324	16.0	1429	32.3	740	18.4	100	24.7	55	1.0
Зориулалтын бус сууц	86	0.6	12	0.3	68	1.7	1	0.2	5	0.1
Бусад	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

### Хүснэгт 14.3 Орон сууцны төрөл байршлаар

	Бүгд	Байршил			
		Хөдөө	Сумын төв	Тосгон	Аймгийн төв
<b>Бүгд</b>	14562	5721	4011	405	4425
Гэр	12152	5661	3203	304	2984
Байшин	2324	55	740	100	1429
Зориулалтын бус сууц	86	5	68	1	12

### Орон сууцны халаалтын төрөл

Халаалтын төрөл	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>Бүгд</b>	<b>1636</b>	<b>1100</b>	<b>526</b>	<b>2324</b>	<b>1529</b>	<b>795</b>
Төвлөрсөн	583	559	24	1052	1017	35
Төвлөрсөн бус	456	374	72	282	130	152
Нам даралтын зуух	456	384	72	275	125	150
Цахилгаан халаагуур	-	-	-	7	5	2
Ердийн галлагаа	597	167	430	990	382	608

### Дүгнэлт

Барилгын салбарын судалгааг ерөнхий ба барилгын түүхийн судалгааг хамтад нь харуулахыг зорьсон. Говь-Алтай аймаг нь Монгол улсдаа газар нутгийнхаа хэмжээгээр 2-рт буюу Өмнөговь аймгийн дараа ордог. Монгол орны баруун урд хэсэгт орших 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, хойд талаараа Завхан, зүүн талаараа Баянхонгор, баруун талаараа Ховд аймаг, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай тус тус хиллэдэг. Засаг захиргааны 18 сум, 87 багтай.

Аймгийн төв Алтай хот нь Улаанбаатар хотоос 1037 км алслагдсан, эх газрын эрс тэс уур амьсгалтай учир цаг агаарын гамшигт үзэгдэл тохиолдох нь элбэг, эдийн засаг нь байгаль, цаг уурын нөхцөлөөс хараат байдаг. Бусад аймгуудын төвөөс Алтай хот нь хамгийн өндөрт өргөгдсөн бөгөөд далайн түвшнээс дээш 2181 метр, ойролцоогоор Богд хан уулын оройтой тэнцэхүйц хэмжээний өндөрт оршдог.

Аймгийн нийт барилга угсралт, шинэ зам, их засварын ажил 2018 онд 22847.4 сая төгрөг байгаа ба улсын нийт барилгын 3.1, баруун бүсийн барилгын 24.3 хувийг тус тус эзлэж байна. Харин аймгийн барилга угсралт, их засварын ажил 2008 оны гүйцэтгэлээс 17.8 тэрбум төгрөгөөр 4 дахин нэмэгдэсэн байна.

Эдийн засгийн хямралт байдлаас болж сүүлийн жилүүдэд барилга угсралт, их засварын ажил буурч байгаагаас гадна хувийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих ажил эрчимтэй өрнөж байна.

Аймгийн хэмжээний нийт орон сууцны тоо жилээс жилд тогтмол өсөж байгаа нь иргэд дулаан тохилог орон сууцанд амьрах хүсэл зорилго ихтэй иргдийн амьжиргаа нь сайжирч байгаатай холбоотой юм.

Иргэд өөрийн хувийн хөрөнгөөр хувийн орон сууц барихад барилгын материалын үнэ өндөр халаалт дулааны хүрэлцээ муу учир энгийн галалгаатай орон сууц их болох хандлагатай байна. Иймд орон сууц нэмэгдэхийн зэрэгцээ халаалтын жижиг зуухнуудын тоо нэмэгдэж агаарын бохирдол нэмэгдэх сөрөг талтай.

Газар чичирхийлэл геологийн мэдээгээр үзвэл, аймгийн Аж богдын нуруунд 7.1-8.0 баллын хүчтэй газар хөдлөлийн төвүүд илэрсэн ба энэ орчмын нутаг нь газар чичирхийллийн идэвхтэй бүсэд багтдаг байна. Мөн багажаар хэмжсэн үзүүлэлтээр бол Алаг хайрхан, Хасагт хайрхан, Хантайширын нуруунд 5.0-6.0 баллын хүчтэй газар хөдлөлтийн төв учир манай аймагт таван давхараас дээш барилга баригдаггүй нь сул тал юм.

Сүүлийн жилүүдэд аймаг орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт нэмэгдэж байгаагаас шалтгаалан томоохон барилга, байгууламж, үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж дулааны эрэлт хэрэглэгчдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгааг харгалзан өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах, хэрэглээний халуун усыг шийдвэрлэх ТЭЗҮ-ийг ойрын хугацаанд яаралтай боловсруулж, төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Дэлгэр сумд хэрэгжих “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх албан байгууллага, айл өрхийг дулаан, цэвэр, бохир усны шугамд холбох ажил, аймгийн төвд болон бусад 17 сумд шинээр дулааны шугам, цэвэр, бохирын шугам барих шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, аж үйлдвэрийн хөгжлийг дагаад тус аймгийн нутаг дэвсгэрт аж ахуйн нэгжүүд нүүрс, алт олборлол үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аймгийн төсөв, орон нутгийн орлогод бага нөлөө үзүүлдэг.

Аймгийн хэмжээнд барилга байшин ихээр баригдаж байгаагийн зэрэгцээ барилгын материал бетон хавтан блок, тоосго, замын хавтан, хашлага, цонх үйлдвэрлэдэг жижиг үйлдвэрлэгчид зах зээлийн өрсөлдөөнөөр бий болж байгаа нь хэрэглэгчдэд өртөг бага тусч, үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний чанар, технологоо сайжруулж үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж ажиллавал илүү үр дүнд хүрэх бололцоотой.

#### **Ашигласан материал**

1. Аймгийн эдийн засаг нийгмийн байдлын танилцуулга 2000-2015 он
  2. Монгол улсын статистикийн эмхтгэлүүд 2010-2016 он
  3. 2009-2016 онд аймаг орон нутгийг хөгжүүлэх цогц бодлого
  4. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
  5. Хүн ам орон сууцны тооллогын ном 2010 он
-